



## Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай сургаалт үлгэр IV: Утгын тайлал I

Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг сургаалт зүйрлэл болохыг бид өмнөх хэдэн нийтлэлд батлан харуулсан. Сургаалт зүйрлэлийн гайхамшиг нь цөөн үгэнд асар гүн утгыг агуулсанд оршино. Их Эзэн Есүсийн хэлсэн үг бүхэн учиртай, нэг ч санамсаргүй үг Түүний амнаас унаагүй гэдэгт бид итгэдэг. Тийм учраас Түүний ярьсан энэ сургаалт үлгэрийн цаад утгыг нь дагалдагч нарын адил Их Эзэнээс асуун байж, Түүний өгөх мэргэн ухаанаар дахиад бүх талаас нь нарийвчлан авч үзээд ойлгож авахыг эрмэлзье (Матай 13:36).

Бусад сургаалт үлгэрийг бодвол энэ үлгэрт утгыг нь тайлах нилээд хэдэн сэжүүр өгөгдсөн байдаг. Библийн бусад хэсгээс холбоос олж тогтоох нь тэдгээр сэжүүрийг тайлж өгөхөд нэмэр болно. Мөн зарим түлхүүр үгийг эх хэлээр нь үзэж тухайн үг Бичвэрүүдэд өөр хаана, ямар утгаар гардагийг шинжиж үзэх нь тустай. Энэ замаар явахад “*Библи өөрөө өөрийгөө тайлбарладаг*” гэсэн Библи судлалын бас нэг зарчим хичнээн үнэн болохыг бид олж харах болно.


*Библи өөрөө  
өөрийгөө  
тайлбарладаг.*

### Баян хүн иудейчүүдийг билэгдэж байна

Библийн үг бүр учиртай гэхэд баян хүнийг танилцуулж байхад хувцсыг нь нарийн тодорхойлсон нь сонирхол татмаар. Тэрээр “*нил өнгийн нарийн нэхсэн маалинган хувцас*” өмсдөг гэсэн (Лук 16:19). Хэрэв энэ өгүүлэл болсон явдал гэж ойлгогдох ёстой байсан бол



баян хүн тамд орохоосоо өмнө ямар өнгөтэй, ямар материалтай хувцас өмсдөг байсан нь огт хамаагүй. Харин өөр утгатай сургаалт зүйрлэлд хувцас нь баян хүний хэн болохыг хэлж өгөх сэжүүр. Хэн болохыг олж мэдвэл яагаад шийтгүүлснийг нь ч бид ойлгох болно.



Дээр үед нил яагаан өнгийг хаад ноёд өмсдөг байжээ (Шүүгчид 8:26, Естер 8:15). Харин нарийн нэхсэн маалингаар хийсэн хувцсыг Израилын тахилч нар сүмийн өргөөнд үйлчлэхдээ өмсөх ёстой. Энэ материал биеийг

хөлөргөдөггүй учраас тэр (Египетээс гарсан нь 28:5,39; Езекиел 44:17-19). Баян хүний хувцас израил ард түмний дуудлагыг санагдуулна. Үүнд: **“Та нар Надад тахилч нарын хаанчлал, ариун үндэстэн болно”** (Египетээс гарсан нь 19:6). Израилчууд энэ дэлхийг тэргүүлэн захирахаас гадна Ертөнцийн Эзэн ба хүн төрөлхтөний хооронд зуучлах тахилчийн дуудлагатай гэсэн үг.

Үүнээс харахад мөнөөх баян хүн израилчуудыг төлөөлдөг. Израилын тэргүүн тахилч Каиаф байж болох санаа ч энэ дүгнэлтэд нийцнэ. Тэргүүн тахилч Ертөнцийн Эзэний өмнө хамаг ард түмнээ төлөөлдөг учраас тэр (Еврей 5:1). Баян хүн ганц хүнээс илүү,



бүлэг хүмүүсийг билэгддэгийг мөн Абрахамын хэрэглэсэн төлөөний нэр харуулдаг. Үүнд: 26-р ишлэлийг бүр үгчлэн орчуулахаар, Абрахам **“эндээс та нар дээр ... очиж үл чадах тийм гүн ангал та нар ба бидний дунд тогтжээ”** гэв (Лук 16:26).

Бусад хүчин зүйлс ч энэ санааг дэмжинэ. Тухайлбал: Баян хүний таван дүүд *“Мосе ба эш үзүүлэгч нар байдаг”* гэсэн (Лук 16:29). Еврейчүүдээс өөр хэнд ч Мосегийн Хууль, эш үзүүлэгчдийн зөгнөлт үг өгөгдөөгүй. Тэд Ертөнцийн Эзэний асар их ивээл ерөөлүүдийг хүртэж, материаллаг амьдралын хувьд чинээлэг байхаас гадна (Эхлэл 15:14; Судрын дэд 17:5,13-18; 32:27-29 г.м.)

сүнсний хувьд ч асар баян байсныг Паул гэрчилдэг:

**“Еврейчүүд бусад үндэстнүүдээс юугаараа илүү юм бэ? Хөвч хөндүүлэх нь тэгээд ямар ашигтай юм бэ? гэж та нар асуух биз ээ. Еврейчүүд олон талаараа бусдаас илүү давуутай. Юуны өмнө Ертөнцийн Эзэн Еврейчүүдэд хандан өөрийнхөө үгийг онцгойлон хэлээд итгэмжлэн хадгалуулжээ...**

**Ертөнцийн Эзэн анх тэднийг өөрийнхөө ард түмэн болгоод [АБ: үрчлэл], яруу алдраа харуулан, үе удам дамжсан гэрээ байгуулаад, хууль тогтоон өгч [АБ: Хуулийн**





гардуулалт], улмаар өөрийг нь хэрхэн өргөмжлөн хүндэлж байхыг тэдэнд зааж өгснөөр барахгүй [АБ: үйлчлэл] онцгой чухал зүйлүүдийг ч амлаж хэлсэн нь бий [АБ: амлалтууд тэднийх].

**Ертөнцийн Эзэнтэй холбоотой амьдарч байсан алдарт Еврейчүүд бол тэдний өвөг дээдэс [АБ: эцгүүд] юм. Басхүү үндэс угсаа болон хүн болж төрсөн талаас нь аваад үзвэл, Ертөнцийн Эзэний томилсон аврагч нь буюу Христ өөрөө тэдний дундаас төрж гарсан билээ”** (Ром 3:1-2; 9:4-5, ББ).

Уг зүйрлэлийн дагуу израилчууд сүнсний хувьд “өдөр бүр найрлан цэнгэдэг” байсан (Лук 16:21). Давид үүнтэй санаа нийлж, Ертөнцийн Эзэн “**надад ширээ засдаг... Аяга минь дүүрч бялхдаг**” гэжээ (Дуулал 23:4-5).

Тэгвэл тансаг идээгээр дүүрэн ширээ бүхий баян хүний хэн болох нь батлагдсан байна: тэрээр Израил ард түмнийг, нарийвчилбал



Есүсийн үед Израилын 12 овгоос үлдсэн Иудагийн үр удам болох иудейчүүдийг бэлэгддэг. Яахобын хүү Иуда, тэрхүү баянтай адил нэг ээжээс гарсан таван ах дүүтэй байжээ (Эхлэл 30:20, 35:23). Иуда овог аймгаас Израилын хаан гаралтай (Эхлэл 49:10). Тахилч хийдэг левичүүд Иудагийн нутагт буй Иерусалимын сүмийн өргөөд үйлчлэхийн тулд Иуда овгийнхонтой нийлж бүгд “иудейчүүд” гэж нэрлэгддэг болсон (Езра 1:5, 4:12).




Ингээд иудейчүүдээс хаан ч, тахилч нар ч гардаг болсныг баян хүний хувцас билэгдэж түүний хэн болохыг тов тодорхой болгодог. Баян хүн Абрахамыг “эцэг ээ” гэж дуудсанд Абрахам түүнийг “хүү минь” гээд үр удмаа гэж хүлээн зөвшөөрдөг нь энэ утгын тайллыг бүрмөсөн батлах хөдөлшгүй баталгаа юм.

### Лазар бусад үндэстнүүдийг билэгддэг

Ядуу гуйлгачин Лазар тэгвэл мөн хувь хүнээс илүү, бүлэг хүмүүсийг төлөөлсөн байж таарна. Фарисайчуудын дорд үздэг, сүнсний хувьд ядуу зүдүү татвар хураагч, янхан, тахир дутуу ба бусад гэмт хүмүүсийг төлөөлдөг нь ойлгомжтой. Харин тэднээс ч илүү Лазар еврей бус үндэстнүүдийг төлөөлдөг.

Еврейчүүдийг Ертөнцийн Эзэн уг нь бусад үндэстнүүдэд үйлчлэх ивээлийн суваг байхаар сонгосон (Эхлэл 12:3). Тэднийг энэ үйлчлэлд зориулахын үүднээс Их Эзэн: **“ЭЗЭН Би ариун бөгөөд та нарыг Би Өөрийнх болгох гэж бусад үндэстнээс салгасан тул та нар Надад ариун байгтун”** гэж хэлсэн (Левит 20:26, АБ, мөн 11:44-45; 19:2; 20:7).





Иймээс ч еврейчүүд өөрсдийгөө Ертөнцийн Эзэний сонгосон ариун хүмүүс гэж үздэг болж, Түүнд тусгаарлан зааглаагүй бусад үндэстэнг еврейчүүд ариун бусд тооцдог болж улмаар бузар муу нохой шиг л ад үздэг болсон.

Лазрыг *ноход* хүрээлж шархыг нь долоодог байсан нь түүний бусад үндэстнүүдийг бэлэгддгийн бас нэг сэжүүр. Тухайн үед нохой хүний хайрладаг тэжээвэр амьтан биш, харин хог ухаж амь зогоох, бохир заваан, жигшил хүрэм золбин амьтан байв.

Есүс хүртэл бусад үндэстний хүмүүсийг нохойтой харьцуулсан энэ зүйрлэлийг Сирофоеник улсын эмэгтэйтэй уулзахдаа ашигласан. Тэрээр: “Хүүхдийн талхыг авч *ноходод* хаях нь зохисгүй” гэхэд тэр эмэгтэй “Тийм ээ, Эзэн. Гэвч *ширээн дор байгаа ноход* хүртэл *хүүхдийн хаясан үйрмэгийг* иддэг шүү дээ” гэж хариулдаг (Маарх 7:24-30). Энд ч гэсэн ивээл дүүрэн ширээний зүйрлэл ба тус ширээнээс унах үлдэгдэл гардгийг анзаарна уу. Еврей бус үндэстнүүд сүнсний хувьд үнэхээр ядуу хоосон, дорой, еврейчүүдийн “талхны үйрмэг” буюу сүнсний ивээлээс өчүүхнийг ч гэсэн хүртэхийг горьддог байсныг тэр эмэгтэй харуулна.

Еврейчүүд ба еврей бусчууд хоёрын хоорондох сүнсний ивээлийн ялгаа нь баян хүн, ядуу Лазар хоёрын хоорондох эдийн засгийн ялгаа шиг асар их байлаа.

Нохдоос ялгаагүй бузарт тооцогддог еврей бусчууд Иерусалим хотын сүмийн өргөөнд орох ч эрхгүй, “Үзэсгэлэнт” хэмээх сүмийн дааман хаалганы цаана өөр үндэстний хүн нэвтэрч орвол цаазлуулдаг болсон (Үйлс



Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай • 7

21:28-31). Энэ нь Ертөнцийн Эзэний өгсөн хууль биш, иудейчүүдийн өөрсдийнх нь гаргасан хууль дүрэм.

Сүмийн тэр л хаалганы гадаа суудаг байсан нэгэн

гуйлгачныг санагдуулах (Үйлс

3:2) Лазар мөн адил баян

хүний гэрт орох эрхгүй,

хаалган дээр л хэвтдэг

байсан. Үүний адилаар

Ертөнцийн Эзэний тусламж

онц хэрэгтэй, гэмээр

өвчилсөн, сүнсний хувьд

гуйлгачин болох энэ дэлхийн

үндэстнүүд Иуда үндэстний ариун гэрт орох эрхгүй,

хаалганы гадна талд л байжээ. Паул бусад

үндэстнүүдийг тодорхойлохдоо, **“Тэр үед та нар**

**Христээс тусгаар, Ертөнцийн Эзэний сонгож авсан**

**ард түмнээс харь хөндий, Түүний амласан үгийг**

**агуулсан гэрээтэй огт холбоогүй байсан учраас**

**ирээдүйд итгэж найдах юмгүй энэ дэлхийд**

**амьдарч байхдаа өргөмжлөн шүтэх Ертөнцийн**

**Эзэнгүй байсан...”** (Эфэс 2:12, ББ).



## Лазарын нэр учиртай

Бас нэг чухал авч үзэх зүйл бол Лазарын нэр. *“Ер нь сургаалт зүйрлэлд хүний нэр гардаггүй учраас Лазар бодит түүхэн хүн”* гэсэн хүч муутайхан аргументыг олон багш нар гаргадаг. Үнэхээр тийм бол өнөөх гуйлгачны нэрийг мэдэж авах нь диваажинд очих тухай бидэнд хэрхэн тус болох вэ? Тийм нэртэй гэхэд бид юуг ойлгох ёстой гэж?



Тухайн үед Лазар гэгч нэртэй хүн олон байсан. Тэгвэл чухам ямар Лазарыг хэлж байгаа вэ?

Үүнээс гадна Есүсийн ярьсан өөр сургаалт зүйрлэлд Хүний Хүү, Сатан зэрэг бодит улсууд гардаг (Матай 13:37, Маарх 4:15). “Сургаалт зүйрлэлд түүхэн хүн юмуу оноосон нэр гардаггүй” гэсэн дүрэм Библийн хаана ч бичигдээгүй. Харин эсрэгээр нь болсон явдалд оролцсон хүний нэр дурдагдахгүй нь түгээмэл<sup>1</sup>. Тийм учраас энэ хоосон “баталгаа”-г тулгуурлах ёсгүй.

Библийн нэг ч үг санамсаргүй бичигдээгүйг бид мэднэ. “Лазар” бол еврей “Елеазар” юмуу “Элиезер” гэгч нэрийн грек хэлбэр бөгөөд “Ертөнцийн Эзэн надад тусалдаг” юмуу “миний хүндэлдэг Эзэн бол туслагч” гэсэн утгатай (Египетээс гарсан нь 18:4). Хэдийгээр бид ядуу Лазарын зүрх сэтгэл, зан чанарын тухай юу ч мэдэхгүй боловч еврейчүүдийн үзлээр “хүний нэр мөн чанарыг нь илэрхийлж, насан туршийн ажлынх нь гол сэдвийг тодорхойлно” (Leiter, 2003). “Ертөнцийн Эзэний туслах нэгэн” гэсэн утгыг тээгч нэртэй Лазар Их Эзэнд найдвараа тавьсан хүн болж таарна.

Үүнээс гадна энэ нэр Лазарын еврей бус үндэстнүүдийн бэлгэдэл болохыг улам илүү баталж өгдөг. Эхлэл номыг үзвэл Абрахамын бүхий л эдлэн хөрөнгийг хариуцдаг даамал зарц яг тийм нэртэй хүн байсан (15:2). Энэ Элиезер еврей хүн байгаагүй, харин Дамаск хотын гаралтай сири хүн (тэр үед

---

<sup>1</sup> Жишээ нь, Лотын эхнэр, Лук 18:18-ын баян удирдагч, Есүсийн эмэгтэй дүүс зэрэг олон бодит хүний нэрийг бид мэдэхгүй.




Абрахамын үр удам болох еврейчүүд үүсээгүй л байсан). Абрахамын хуаранд төрсөн 318 эр зарцыг бодохоор түүний эд хөрөнгө үнэхээр багагүй байлаа (Эхлэл 14:14). Тэр бүхнийг авч явах хариуцлагыг Абрахам Элиезерт даатгасан нь түүний ямар итгэмжит хүн болохыг харуулна.

Элиезер фарисайчуудын адилаар даамал боловч үүргээ тэдэн шиг үнэнч бусаар биш (Лук 16:1-14), харин итгэмжтэйгээр гүйцэтгэдэг байсан нь ач холбогдолтой. Түүнд фарисайчуудын мөнгөнд шунах зан байсангүй. Өндөр настай ч хүүгүй Абрахамын бүхий л өв хөрөнгийг Элиезер өвлөж авах гэж байсан.

Тэр өв хөрөнгөнд асар их баялаг, нэр хүнд, эрх мэдэл, хааны хэргэм, тахилчийн хэргэм, Канааны улс орон болон Ертөнцийн Эзэний бүх амлалтууд ч багтсан.

Гэтэл эцэст нь Абрахамаас Исаак төрөхөд Элиезер өвлөх

эрхээ нэгмөсөн алддаг. Өөрийнх нь оронд Исаак Абрахамын бүх өв хөрөнгийг өвлөхөөр болсныг Элиезер сайн мэдэлгүй яахав. Өөрт нь юу ч үлдээгүй. Ямар ч найдваргүй болсон зарц өв залгамжлагч хүүг янз бүрээр аргалан зайлуулж болох л байсан. Гэтэл





Элиезер үнэнч шударга даамлын хийх ёстой бүхнийг хийсээр л байв. Исаакт зориулж сайн эхнэр олохыг хүртэл Абрахамд тангараглаад хэлсэн амандаа үнэнчээр хүрдэг нь Исаакийг ч өв залгамжлагчтай болоход дэмжлэг үзүүлсэн (Эхлэл 24).

Эцэс хүртэл үнэнч байсныхаа төлөө Элиезер Ертөнцийн Эзэнээс ямар ч амлалт, ямар ч ивээл аваагүй хоцорсон. Эд хөрөнгөнд шунахаас илүү үнэнч шударга байхыг эрмэлзсэн тэрээр “муугаа авсан ядуу нэгэн” (Лук 16:25). Гэсэн хэдий ч “Ертөнцийн Эзэн миний туслагч” гэсэн нэрийнх нь утгын ёсоор Ертөнцийн шударга Эзэн өөрт нь туслах цаг ирнэ гэдэгт Элиезер нөгөө Сирофоеник улсын эмэгтэйн адил итгэдэг байсан нь эргэлзээгүй. Элиезерийг эцэст нь “Абрахамын өвөр дээр” сууж байхыг дүрслэхдээ Есүс түүний ба түүн шиг хүний итгэл талаар өнгөрөхгүйг энд мөн баталсан байна.

## **Абрахамын өвөр дэх хүндэт байр суурь**

Баян хүн, ядуу Лазар хоёр хоёулаа нас барснаар доорх зурган дээр харуулсанчлан байр нь солигдсон. Энэ нь иудейчүүд ба үндэстнүүдийн аль алины хувьд сүнслэг нөхцөл байдалд нь үндсэн өөрчлөлт орсоныг илэрхийлдэг.

Олон зууны турш еврейчүүд Абрахамын үр удам болж төрсний ачаар Ертөнцийн Эзэний сонгогдсон ард түмэн болохын хувьд онцгой ивээл ерөөлүүдийг нь дангаараа эдэлдэг байсан (Дэд хууль 32:9-14, Езекиел 16:8-13). Харин тэд итгэмжтэй байгаагүйн



улмаас Лазарын билэгддэг бусад үндэстнүүд иудейчүүдийн ивээл ерөөл дүүрэн хүндэт байр сууринд шилжих гэж буйг энэ сургаалт үлгэр битүүхэн илэрхийлдэг.

Лук 16:22-23-г бүр нарийн орчуулахаар тэнгэр элч нар

Лазарыг Абрахамын “өвөр дээр тавьсан” биш, “өвөрт нь аваачсан” учраас Лазар “түүний өвөр дэх” байранд орсон. Есүсийн үед хүмүүс зоог барихдаа ширээг тойрон суух биш, тойрон хэвтдэг байсан бөгөөд ингэхэд нэг хүний толгой нь ард нь буй хүний цээжтэй ойрхон байршилтай байсан. Гэрийн эзний цээжийг ийн налаад хэвтэх буюу “өвөр дэх нь байх” хамгийн дотно ба хүндэт зочны л онцгой эрх. Яг энэ ойр дотно байдлыг бид “Есүсийн цээжийг налаад сууж” байсан Иоханаас хардаг (Иохан 13:23, “өвөр”, “цээж” гэдэг нь грек хэл дээр нэг л үг болно). Есүс Өөрөө ч “Эцэгийн өвөр дэх Хүү” мөн (Иохан 1:18).

Чухам энэ ойр дотно, хүндэтгэлийн байр суурийг “Абрахамын өвөр дэх” байгаа Лазар эдэлж байгааг тухайн хэллэг билэгддэг. Иймээс Лазар тансаг зоогон



дээр ирсэн төдийгүй, олон үндэстний өвөг эцэг Абрахамын өвөр налсан хамгийн хүндэт суудлыг эзлэн жаргаж буйг энэ зураглал харуулдаг.

Бэлэгдлээр бус, шууд үгээр ч гэсэн Есүс энэ тухай хэлсэн байна. Үүнд: **“Дорноос хийгээд өрнөөс олноороо ирцгээж, тэнгэрийн**



**хаанчлалд Абрахам, Исаак, Иаковтай хамт ширээнд тухлах болно. Харин хаанчлалын хөвгүүд гаднах харанхуйд хаягдана. Тэнд уйлаан, шүд хавирах нь буй...”** (Матай 8:11). **“Дорноос хийгээд өрнөөс бас өмнөдөөс хийгээд умардаас олноороо ирж Бурханы хаанчлалд ширээнд тухлах болно. Үзэгтүн, [Лазар шиг] сүүлд байгаагаас зарим нь эхнийх болж, [Израилын удирдлага шиг] эхэнд байгаагаас зарим нь сүүлчийнх болно”** гэж Есүс Хаант улсын тухай хэлсэн (Лук 13:29-30). Тэр Хаант улсад Лазар мэт итгэмжтэй еврей бусчууд хүндэт байр суурьтай болж, “хаанчлалын хөвгүүн” болох баян хүний төлөөлсөн итгэмжгүй еврейчүүдийн Хаант улсад орохгүй байх зовлонг энд тод хэлсэн байна.

Гэтэл Лазар Хаант улсад орох үндэстнүүдийг төлөөлөөд зогсохгүй, Христийн Биед орох үндэстний хүмүүсийг бас тодорхой хэмжээгээр төлөөлнө.



“Тэнгэр элч” гэж орчуулдаг грек үг (G32) ердөө л “хэл мэдээ хүргэгч, зарлага” гэсэн утгатай, заавал тэнгэрээс ирсэн байх албагүй, хүн ч байж болно<sup>2</sup>. Есүс энэ өгүүллэгийг ярьснаас хэдэн жилийн дараа тэнгэрээс томилогдсон нэгэн элч еврей бус хүмүүс рүү илгээгдсэн. Тэр бол Есүсийн зарц, үндэстнүүдийн апостол болсон Паул билээ (Галат 2:2; Колоссай 1:23; 1 Тимот 2:7; 2 Тимот 4:17). Христийн тухай сайн мэдээг нь хүлээн авч, итгэсэн хэн ч болов тэр л өдөр гэмийн хувьд нас барсан ба шинэ амьдралтай болсонд тооцогддог (Ром 6:11).

Эрт дээр үед дөнгөж төрсөн хүүхдийг хүний өвдгөн дээр тавихаар тэр хүний хүүд тооцдог байжээ (Эхлэл 30:3). Лазарыг Абрахамын өвөр дээр тавьсан нь түүнийг Абрахамын хүү болсныг харуулсан билэгдлийн чанартай. Үүнчлэн Есүст итгэсэн еврей бус хүн Абрахамын итгэлийн хүүхдэд тооцогддог.

Үүнд: **“Абрахам “Бурханд итгэсэн бөгөөд үүгээр нь түүнийг зөвд тооцсон” юм. Тиймээс итгэлийн хүмүүс нь Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав... “Бүх үндэстэн чамаар ерөөгдөх болно” гэж Абрахамд сайн мэдээг урьдчилан тунхаглажээ. Тиймээс итгэлийнхэн нь итгэлийн хүн Абрахамын хамт ерөөгдсөн аж... Хэрэв та нар Христийнх юм бол та нар Абрахамын үр бөгөөд амлалтын дагуу өв залгамжлагчид мөн”**  
(Галат 3:6-9,29).

---

<sup>2</sup> Жишээ нь, Матай 11:10-т Иохан Баптистыг энэ грек үгээр дууддаг. Иаков 2:25-т Рахаб дээр ирсэн хоёр тагнуулыг мөн ингэж нэрлэсэн.



Еврей бус итгэгчид  
“цаашид гаднынхан болон  
цагаач хүн бус, харин  
ариун хүмүүсийн адил  
нутгийн иргэд бөгөөд  
Бурханы гэр бүлийнхэн”  
болсныг Абрахамын өвөр  
илэрхийлдэг (Эфэс 2:19).



Учир нь “Өөрөөс нь хол хөндий байсан та нарыг  
Ертөнцийн Эзэн одоо Есүс Христтэй нэгдмэл  
болгоод Түүний урсгасан цусны хүчээр өөртэйгээ  
*ойртуулан дотносуулсан байна*” (Эфэс 2:13, ББ).  
Абрахамын цээжийг налж тухлахаар гавьяа  
байгуулаагүй Лазарын адилаар “Ертөнцийн Эзэний  
өмнө өөрсдийгөө гэмгүй болгох гэж тэгтлээ нэг их  
хичээж оролдоогүй еврей бус үндэстнүүд түүгээр  
гэмээ цагаатгуулсан...  
Гэтэл Ертөнцийн Эзэний тогтоосон хуулийг  
дагасныхаа үндсэн дээр гэмээ цагаатгуулахыг  
оролдсон израйльчууд хичнээн ч хичээгээд  
амжилт олсонгүй” (Ром 9:30-31, ББ).  
Иудейчүүд баялаг бялхсан ширээнээс Үхэгсдийн  
орон руу шилжсэн нь

Баян хүн чухам хэн болохыг мэдэж авахад түүний  
яагаад зовлонт байдалд орсон нь ч ойлгомжтой болж  
эхэллээ. Баян хүн уг нь Лазарт эм, хоол, хувцас, ажил  
өгч өөд нь татаж болох байсан ч тэгээгүй. Гэрийнх нь  
гадаа нохдын дунд хэвтэж буй тэр хүнд хааяа нэг  
хоолны үлдэгдлээсээ хаяхаас хэтрээгүй. Хамаг  
баялгаа Ертөнцийн Эзэнээс Түүнд үйлчлэх гэж л



итгэмжлэн авснаа баян хүн ойлгож, зөв ашигласан бол нөгөө тамдаа орохгүй л байхсан. Даанч хандлага нь фарисайчуудынхаас өөрцгүй. Баялаг нь өөрийг нь ямар сайн хүн болохыг харуулдаг гэж үзсэн болохоос өөрийг нь харин ч ямар өөдгүй болгон хувиргасныг анзаарсан ч үгүй.

Үүнчлэн израилчууд дуудлагынхаа дагуу бусад үндэстнүүдэд Их Эзэний тухай заагаад өгч, ивээлийг нь дамжуулах суваг болох ёстой байхад мөн ч



тэгээгүй. Сүнсээрээ ядуу дорой бусад үндэстнүүдийг өрөвдөн хайрлаж, ширээндээ урьж, баялгаа хуваалцахын оронд харин ч тэднийг ад үзээд үл тоон зөнд нь орхижээ. “Ертөнцийн Эзэн биднийг л Өөрийн ард түмэнд сонгосон” гээд өөрсдийгөө бусдаас илүүд үзээд бардам ихэмсэг болсон нь тэр. Үнэн хэрэгтээ энэ нь бусад үндэстэнд үйлчлэхээр өөрсдийг нь дуудсан Их Эзэнийг ч үл тоомсорлосон хэрэг. Бэлэглэгч Эзэнээс илүү

тэд бэлгийг нь чухалд тоосон гэсэн үг. Тийм муухай бардамналыг Ертөнцийн Эзэн үзэн яддаг бөгөөд хүн ийм зан гаргасанд уурлахаас өөр яах вэ. Иймээс ч



израилчуудын ивээл нь хараал болж хувирсан буюу сүнсний баялгийг бэлэгддэг **“зоогийн ширээ нь тэдний унаж тусах урхи занга”** болсон (Ром 11:9).

Баян хүний билэгддэг иудейчүүд бусад үндэстнүүдэд Ертөнцийн Эзэний ивээлүүдийг дамжуулах суваг байх дуудлагаа биелүүлээгүйгээс гадна Үхэгсдийн оронд орохоор олон муу үйлс хийсэн. Есүс тэднийг бүр “хорт могойн удам” (Матай 12:34), “хорон муу болоод завхай үеийнхэн” (Матай 12:39), “итгэлгүй, тэрслүү үеийнхэн” (Матай 17:17), “хоёр нүүрт хүмүүс” (Матай 22:18), “сохор газарчид” (Матай 23:16), “цагаанаар будсан булшнууд шиг гаднаа гоё сайхан харагддаг хэдий ч дотроо үхэгсдийн яс болоод бузар бүхнээр дүүрэн” (Матай 23:27) гэх мэтээр хамгийн муугаар тодорхойлдог. Учир нь Ертөнцийн Эзэний Үгийг



даамал мэт итгэмжлэн авсан байж (Ром 3:2) Израилын ахлагчид харин ч мөнгөнд буюу өөр эзэнд үйлчилдэг байсны улмаас Их Эзэний үгийг хүчингүй болгодог байсан<sup>3</sup>.

<sup>3</sup> Ганц хоёр жишээг дурдахад, Марк 7:7-13-т фарисайчууд хүний аав ээждээ туслах мөнгийг “Ертөнцийн Эзэнд өргөх өргөл” болгоод өөрсдөө л авах гэж 10 Тушаалын 5 дахийг нь (“Эцэг эхээ хүндэл”) хүчингүй болгосон. “Эхнэрээ ямар ч шалтгаанаар хамаагүй салж явуулж болно” гэж фарисайчууд зааж байснаараа завхайрахыг хориглодог 7-р тушаалыг хүчингүй болгодог байсан (Лук 16:18).



Тиймээс тэд “ажлаасаа халагдах”-аар болсныг Есүс 4-р сургаалт зүйрлэлээрээ илэрхийлсэн (Лук 16:1-13).  
Паул иудейчүүдийн тухайд: **“Өөрсдийнх нь гэм буруутай байдлаас болоод өөр үндэстнүүд аврал (олсон)...”** гэж бичив (Ром 11:11, ББ).


Тэд өөрсдийгөө Абрахамын удам гэж сайрхдаг боловч Ертөнцийн Эзэний үгийг Абрахам шиг үнэмшин дагасангүй. Иймээс тэд махбодын хувьд Абрахамын удам мөн ч гэсэн доторх байдлаараа адгийн муу ёрын сүнсний хүүхдүүд болохыг Есүс фарисайчуудад шууд хэлдэг (Иохан 8:33-44). Иймээс баян хүн Абрахамыг гурван удаа “эцэг” гэж дуудсан ч Абрахам эргээд нэг л удаа “хүү минь” гэж хариулж махбодын холбоосыг хүлээн зөвшөөрсөн ч дараа нь ингэж хариулахгүйгээрээ баян хүнийг итгэл үйлсийн хувьд өөрийнх нь үнэн хүү биш болохыг илэрхийлдэг.

“Учир нь гаднах байдлаараа иудей байх нь иудей биш... Харин доторх байдлаараа иудей байх нь иудей хүн мөн... Абрахамд хозлолоос нь өмнө байсан итгэлийн мөрөөр мөшгөгч хозлуулсан хүмүүст тэрээр хозлолын эцэг болсон.” (Ром 2:28-29; 4:12).

Үүнээс гадна иудейчүүд Мосегийн ирнэ гэж зарласан эш үзүүлэгчийг хүлээж аваагүй. Эрт дээр үеэс эш үзүүлсэн олон үгийг Есүс биелүүлж тэр л Эш үзүүлэгч болохоо баталсан боловч тэд Түүнийг хүлээж аваагүй, Ертөнцийн Эзэний нэрээр ярьсан үгийг нь сонсоогүй. Тийм хүн Ертөнцийн Эзэний шийтгэлийг хүлээх болно гэж Мосе эрт дээр үед ч сануулсан (Дэд хууль 18:15-19). Гэвч тэд Есүсийг үл сонсоод зогсохгүй Түүнийг



эцэст нь бүр хэрцгийгээр алсан нь Ертөнцийн Эзэнээс урвасан дээд зэргийн хэрэг билээ. Энэ бүхний төлөө шийтгүүлж, Ертөнцийн Эзэнээс салж, Түүний онцгой хайрлан, анхаарал халамж тавьсан ард түмэн нь байхаа болих еврейчүүдийн хувь заяаны талаар Есүс баян хүний тухай сургаалт үлгэрээрээ зөгнөсөн билээ.



Баян хүн нас барж оршуулагдан Үхэгсдийн оронд (грек Хадес) орсон. Хадес гэдэг үгийн суурь утга нь “харагдахгүй нь”, “үл үзэгдэхүй нь” гэсэн утгатай (*The New International Dictionary of New Testament Theology*-ын 2-р боть, 206-р х.).

Энэ нь газарт оршуулагдсан хүний үл харагдах, үл мэдэгдэх байдлыг хэлэхээс гадна, шилжсэн утгаараа тасарсан харилцааг илэрхийлдэг. Тухайлбал, тэнэмэл хүү нас бараагүй байхдаа ч гэр бүлийнхээ хувьд “үхсэн байсан” (Лук 15:32). Ааваасаа холбоогоо таслаад сураггүй болсон нь тэр. Үүнчлэн баян хүн “нас барж” “үзэгдэхгүй”-д орсон. Нэг л сургаалт зүйрлэлийн тус хоёр цуврал хэсэг нэг л ижил утгаар холбогдсон байгаа нь тодорхой.

Есүс энэ тухай мөн, “Харж байгтун! Ертөнцийн Эзэн хотыг чинь орхих [хот чинь хоосон зэлүүд] болно...” гэж хэлсэн (Матай 23:37, 38, ББ). МЭ 70 онд Ромын цэргүүд Иерусалим хотыг сүмийнх нь хамт үнсэн товрог болтол нь сүйтгэн шатаасан. Иудейчүүд сүмгүй болохдоо Мосегийн Хуулийн олон ёс заншил дагаж



чадахаа больжээ. Их Эзэн бусад үндэстэнд ивээлийн суваг болох хүндэт байр суурьнаас нь тэднийг зайлуулсан. Ингээд иудейчүүд улс төрийн хувьд ч, итгэл бишрэлийнхээ хувьд ч “үзэгдэхгүй” болжээ.

Мосе ч дээр үед еврейчүүдийн хийх гэм ба хариуд нь авах шийтгэлийн тухай зөгнөсөн байна. Үүнд:

Тэд **“Өөрийг нь бүтээсэн Бурханыг орхиж,  
Өөрсдийг нь аварсан Хадыг үл ойшоов.**

**Харь газрын жигшүүрт бузар юмсаар**

**Харамнах сэтгэлийг нь хөдөлгөж,**

**уур хилэнг нь өдөөв.**

**Өргөл тахилаа тэд Бурханд биш**

**чөтгөрүүдэд өргөв...**

**Үүнийг үзээд ИАВЭ жигшжээ.**

**Охид хөвгүүд нь Түүнийг хилэгнүүлжээ.**

**Иймээс ИАВЭ ийн айлдав.**

**«Итгэмжгүй, гажиж буруудсан үеийнхэн**

**Эднээс Би нүүр буруулна**

[=тэд Түүнд үзэгдэхгүй болно].

**Эцэс сүүлдээ юу болохыг нь үзнэ.**

**Бурхан бус зүйлээр хар хорыг минь хөдөлгөж,**

**Хуурмаг хоосон юмаар**

**уур хилэнг минь өдөөсний учир**

**Хүн гэхэд хэцүү хүмүүсээр Би атааг нь хөдөлгөж**

**Харанхуй мунхаг үндэстнүүдээр уурыг нь хүргэнэ.**

**Уур хилэнгийн минь улмаас гал дүрэлзэж**

**Үхэгсдийн орны ёроолд хүртэл шатна.**

**Уул толгодын суурьд гал хүрч**

**Ургацыг газартай нь хуйхална.**

**Гай зовлонг тэдний дээр овоолж**



## Гамшгийн сумыг тэдэн рүү харвана...»” (Дэд Хууль 32:15-23).

Их Эзэний уур хилэнгийн тэр гал нь тамд буй сүнсийг тарчилгадаг гал биш, харин газар дэлхийг цөлмөн сүйтгээд, амьд яваа израилчууд дээр ирэхэд “Өлсгөлөнгөөр тэд үлгэн салган болж,



Халуун тахал, гашуун сүйрэл...д мөхөж сүйрнэ.” Дээр нь Их Эзэн “тэдэн уруу араатны шүд, тоос шороонд мөлхөгчдийн хорыг илгээнэ”.

Тэгэхэд “Гадаа хагацлын илд бууж Гэрт айдас түгшүүр болно...” гэх зэрэг Их Эзэний айлдсан энэ бүх шийтгэл олон зууны турш израилчуудад ирсэн (Дэд Хууль 32:23-25).

Газар дэлхий бүхлээрээ шатаж амжаагүй нь энэ зөгнөл биелэгдэхээ дуусаагүйг ч харуулна.

Ертөнцийн Эзэн уурандаа нүүрээ буруулахад израилчууд “Үхэгсдийн орон”-ы үл үзэгдэх байдалд оржээ. Тэр үзэгдэхгүй орны гүн хүртэл дүрэлзсэн Түүний уур хилэнгийн чухам энэ галд тухайн баян хүн тарчилж байна. Энэ нь иудейчүүд өнгөрсөн 2000 жилийн турш байнга л хавчлага зовлонд ордог байснаар биеллээ олсоор байна.



Лук 16:24-д “амь тэмцэх” гэж орчуулсан грек үг (G3600) 25-р ишлэлд дахин гарахдаа “зовох” гэж орчуулагдсан. Энэ үг мөн Лук 2:48 ба Үйлс 20:38-т гардаг. Лук номонд 12 настай Есүсийн аав ээж хоёр нь Түүнийг хайгаад олж чадахгүйдээ “санаа зовдог” (G3600). Үйлс номонд эфэсчүүд Паултай дахиж уулзахгүйдээ “гуниглацгаасан” (G3600). Үүнээс харахад энэ үг сэтгэлийн зовлонг хэлдэг. Бие махбодын зовиураас сэтгэлийн зовлон хэцүү байдгийг олон хүн баталж чадна. Иудейчүүдийн хамгийн их зовлон тэгвэл сэтгэл санааных гэдэг нь тодорхой.<sup>4</sup>

### Эхний ээлжийн дүгнэлт

Баян хүн иудейчүүдийг билэгддэг бөгөөд ядуу Лазар бусад үндэстнүүдийг төлөөлдөг нь тодорхой. Иудейчүүд Ертөнцийн Эзэний дуудлагаар хаад ба тахилч болж, бусад үндэстнүүдийг сүнслэг баялгаараа ивээх учиртай. Гэвч иудейчүүд бусад үндэстэнг голж, нохдын дунд тооцсон. Мосегийн зөгнөлийн дагуу Их Эзэн үгийг нь зөрчсөнөөс нь болж тэднийг орхиж, “Үхэгсдийн орон” буюу “үзэгдэхгүй байдал”-д оруулна. Түүний шийтгэл галтай зууханд байгаа юм шиг зовлонтой.

Харин бусад үндэстэн Ертөнцийн Эзэний сүнслэг ивээлүүдийг Израилаар дамжилгүй, шууд хүртдэг болсон. Үндэстний хүмүүс Абрахамын итгэлийн хүүхэд болж, Абрахамын хүртсэн ивээлийг хуваалцан эдлэх

<sup>4</sup> Зовлонг хэцүү байдлыг шилжсэн утгаар галтай “зуух”, “Үхэгсдийн орон” гэж нэрлэсэн бас хоёр жишээг Дэд Хууль 4:20, Иона 2:2-с олж уншина уу.



## Баян хүн ба Лазарын өгүүллэгт орсон билэг тэмдэг

Баян хүн	Тэргүүн тахилч Каиаф, Яахобын Иуда буюу иудейчүүд
-нил ягаан өнгөтэй	Хаанчлалын үүрэг
-маалинган хувцас	Тахилчийн үүрэг
-тансаг зоог	Ертөнцийн Эзэний бүх сүнслэг ивээлүүд
Лазар	Абрахамын итгэмжтэй даамал Элиезер, еврей бус үндэстнүүд
-ядуу	Ертөнцийн Эзэний амлалт, сүнслэг ивээлүүдийг аваагүй
-ноход	Еврей бус үндэстнүүд
нас барах	амьдралын нөхцөл байдалд том өөрчлөлт орох
тэнгэрэлч	Их Эзэний сайн мэдээ хүргэдэг элч төлөөлөгч
Абрахамын өвөр дээр суух	Абрахамын хүү болж, түүнд өгсөн Ертөнцийн Эзэний амлалт ивээлүүдийг хуваалцан эдлэх, Хаант Улсад хамт зооглох
Үхэгсдийн орон	Үзэгдэхгүй байдал, харьцаагүй байдал

боломжтой болсон. Тэнгэрээс дуудан илгээгдсэн элч Паулын тунхагласан сайн мэдээнд итгэсэн хүн бүр Абрахамын хүүхэд мөн бөгөөд өнөөдөр ч бүхий л сүнслэг ивээлээр ивээгдсэн юм.

Хайр ивээл дүүрэн Их Эзэндээ сэтгэлийн гүнээс талархъя! □

*Дараагийн нийтлэлд бид баян хүн, ядуу Лазар хоёрын тухай сургаалт зүйрлэлийн утга учрыг цааш нь задлан харна.*

### Ашигласан эх сурвалж:

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.



- Brown, C. (1975). The New International Dictionary of New Testament Theology.
- Bullinger, E. W. (1902). The Rich Man and Lazarus: An Intermediate State? <http://www.biblical-data.org/LAZARUS.pdf>
- Dawson, S. G. (1943). The rich man, Lazarus, and the afterlife. [www.truthaccordingtoscripture.com](http://www.truthaccordingtoscripture.com)
- Eby, J. P. (n.d.). Abraham's bosom: A treatment of the parable of the rich man and Lazarus. <https://godfire.net/eby/abrahams.html>
- Froom, L. E. (1966). Gravity of Ascribing False Teachings to Christ. [www.truthaccordingtoscripture.com](http://www.truthaccordingtoscripture.com)
- Gill, John (1690-1771). Exposition of the Entire Bible. [www.biblehub.com](http://www.biblehub.com)
- Huie, B. T. (1998). Lazarus and the rich man. [www.tentmaker.org](http://www.tentmaker.org)
- Leiter, S.Y. (2003). Grasping the Heel of Esau. [www.chabad.org](http://www.chabad.org)
- Martin, E. L. (2003). The real meaning of Lazarus and the rich man. <http://www.what-the-hell-is-hell.com/HellArticles/RichManParable.htm>
- Smith, L. R. (n.d.). Lazarus and the Rich Man: A scriptural journey through the intriguing parable of Lazarus and the rich man. [www.bible-truths.com](http://www.bible-truths.com)
- Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Patching, J. The rich man and Lazarus. <http://www.tentmaker.org/books/RichManandLazarus-Patching.html>
- Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)
- Wilson, Larry (2007). The rich man and Lazarus. Wake up America Seminars. [www.wake-up.org](http://www.wake-up.org)
- Witherell, J. F. (1843). Rich man and Lazarus. In *Five Pillars in the temple of partialism removed*. Concord: Balm of Gilead.